# ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА СҮХБААТАРЫН ОРХОНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024.12.15

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин, хэрэгжилт | Гүйцэт гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах | | | | | | | |
| 1.1.1. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Шаард-лагагүй | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэх дүрэм, журам, чиглэл, зааврыг баримтлан ажиллаж байна. Тухайлбал, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолын дагуу 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын сангаас олгож байгаа бүх төрлийн тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр авагч нийт 18121 хүний тэтгэврийг 100,000 төгрөгөөр нэмэгдүүлж олгон, нэмэгдлийг тэтгэвэр тогтоолтын хуудаст тэмдэглэл хийн баталгаажуулж ажиллав. Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Шийдвэр хүргүүлэх тухай” 2024 оны 04/460 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу тус газрын дэргэдэх “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл”-ийг 9 удаа хуралдуулж 53 даатгуулагчийн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд хэлэлцүүлсэн нийт асуудлын 91 хувь нь малчнаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллаж шимтгэл төлсөн хугацааг тооцуулах, 8 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, 1 хувь нь бусад асуудлаарх хүсэлт тус тус эзэлж байна. Төв аймгийн Нийгмийн даатгалын газар нь 05 дугаар сараас иргэд, даатгуулагч, ажил олгогчид үйлчилгээг илүү хялбар авах боломжийг бүрдүүлэх зорилгоор 70274004 дугаарын (callpro) дуудлагын лавлах утасны үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү лавлах утсанд нийт 1562 дуудлага ирснээс 85 хувьд нь буюу 1329 дуудлага бүрт тус газрын холбогдох байцаагч, мэргэжилтнүүд тухайн цаг үед нь хариулт өгч, асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна. Харин алдагдсан 233 дуудлага алдагдсаны 38 нь даатгуулагчаас шалтгаалсан, 195 дуудлагад холбогдох байцаагч ажилтнууд даатгуулагчтай эргэн холбогдож асуудлыг шийдвэрлэсэн болно. | |
| 1.1.2. | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | Шаард-лагагүй | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, дээд газарт хүргүүлсэн мэдээ, тайлангийн тоо | 2023 онд 370 хүнийг сайн дурын даатгалд шинээр, үүнээс 182 малчин шинээр хамруулав. | Сайн дурын даатгалд 2024 онд 604 даатгуулагч, үүнээс 216 малчин даатгуулагчийг шинээр хамруулж, хамралтын төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд газрын даргын 2024 оны 28 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар “Сайн дурын даатгалын орлогын 2024 оны төсвийн хуваарь”-ийг, мөн тушаалын наймдугаар хавсралтаар ”2024 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах сайн дураар даатгуулагчийн тооны төлөвлөгөө”-г тус тус баталж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Нийгмийн даатгалын багц хууль, нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд 2024 онд нийт 154 удаагийн сургалт, сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулж, эдгээр арга хэмжээнд нийт 173 ажил олгогч, 5529 даатгуулагч иргэдийг хамруулав. Тухайлбал: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран “Нээлттэй хаалганы өдөрлөг”, “Нийгмийн салбарын явуулын үйлчилгээ” арга хэмжээг Алтанбулаг, Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Баянцогт, Заамар, Эрдэнэ, Эрдэнэсант сумын 897 иргэд, даатгуулагчдад, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран “Малжуулах төсөл”-ийн хүрээнд 23 сумын 1200 гаруй иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын багц хууль, сайн дурын даатгалын талаар сургалт зохион байгуулж, мэдээлэл хүргэж ажиллав. Мөн аймаг, сумын багийн иргэдийн нийтийн ээлжит 36 удаагийн хуралд оролцож 1695 даатгуулагчид, 51 ажил олгогч, байгууллагын 1350 албан журмын даатгуулагчийг тус тус хамруулсан байна.. Мөн байгууллагын фэйж хуудсанд 3 удаагийн видео контент бүтээж иргэд даатгуулагчдад түгээсэн. Түүнчлэн Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга, үйлчилгээний талаар 25 постер мэдээлэл, 13 төрлийн үйлчилгээний гарын авлага боловсруулан хэвлүүлж нийтдээ 6500 орчим гарын авлага, тараах материал түгээн, сургалт сурталчилгаанд ашигласан байна. Дээрх арга хэмжээг үе шаттай зохион байгуулсны үр дүнд нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчдын тоо 2024 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 5250 хүрсэн байна. Малчдын төлбөл зохих шимтгэлийн тодорхой хувийг төрөөс төлүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд 2733 малчныг хамруулж 1244.6 сая төгрөгийг улсын төсвөөс төлүүлэв. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийгмийн даатгалд сайн дураар 5754 даатгуулагчийг хамруулахаас 5250 даатгуулагчийг хамруулж 91.2 хувийн биелэлттэй байна. Шинээр нийгмийн даатгалд сайн дураар 604 даатгуулагчийг хамруулахаас 619 даатгуулагчийг хамруулж 100.8 хувийн биелэлттэй байна. Үүнд: Нийгмийн даатгалд сайн дураар энгийн 126 даатгуулагч хамруулахаас 127 даатгуулагчийг хамруулж 100.7 хувь, 0-3 насны хүүхдээ асарч буй эх 75 даатгуулагч хамруулахаас 81 даатгуулагчийг хамруулж 108 хувь, 216 малчин даатгуулагчийг шинээр хамруулахаас 1072 малчныг хамруулж 500 хувиар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх 187 даатгуулагч хамруулахаас 74 даатгуулагчийг хамруулж 40.4 хувийн тус тус биелэлттэй байна. | |
| 1.1.3. | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | Шаард-лагагүй | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо | 2023 онд 119 ажил олгогч, 283 хүнийг албан журмын даатгалд шинээр хамруулав. | Ажил олгогчийн тоог 81, даатгуулагчийн тоог 300 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор газрын даргын 2024 оны 28 дугаар тушаалын наймдугаар хавсралтаар ”2024 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах албан журмын даатгуулагчийн тооны төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тайлант хугацаанд 899 ажил олгогчийн 16970 даатгуулагчийн нийгмийн даатгалын тайланг цахимаар хүлээн авч баталгаажуулсны 75 ажил олгогчийн 295 даатгуулагчийг нийгмийн даатгалд албан журмаар шинээр хамруулсан байна. Мөн 34 ажил олгогчид тоон гарын үсгийг олгон төрийн үйлчилгээнд шуурхай хамрагдах нөхцөлийг бүрдүүлэв. | 100 |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах | | | | | | | |
| 2.1.1. | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл | Нийгмийн даатгалын санд 2023 онд 42,051.5 төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 121,095.6 төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд 56.7 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогыг хуримтлуулах төлөвлөгөөтэй ажилласнаас тус аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж, нийгмийн даатгалын шимтгэл төлж тайлагнаж буй 899 аж ахуйн нэгж, байгууллагын 56.3 тэрбум төгрөг, сайн дурын нийгмийн даатгалд хамрагдаж буй 5250 даатгуулагч иргэдээс 3.5 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогыг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж төлөвлөгөөг 105.4% биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын санд 59.8 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн нь 2023 оны мөн үетэй харьцуулбал орлого 10.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. | 100 |
| 2.1.2. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл | Нийгмийн даатгалын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны урсгал зардалд ... сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | Газрын үйл ажиллагааны урсгал зардалд НДЕГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/201 дүгээр тушаалаар 2.1 тэрбум төгрөгийн зардлыг төсөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 2.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн хуваарийн дагуу 2.1 тэрбум төгрөг буюу 100% зардал, ангиллын дагуу зарцуулж, төсвийн сахилга, хариуцлагыг чангатган Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу өр үүсгэлгүй ажиллалаа. Батлагдсан бүтэц орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн хүний нөөц, үйл ажиллагаатай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн өр, бусад өр үүсгэлгүй зардал, ангиллын дагуу зарцуулан төсвийн сахилга, хариуцлагыг чанд мөрдөн ажиллалаа. “Журам батлах тухай” | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ын хүрээнд 2024 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр Нийгмийн даатгалын газрын 47 албан хаагчид 103.4 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдэл олгоод байна. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу орон нутагт төрийн захиргааны албан тушаалд томилогдон тасралтгүй 5 жил ба түүнээс дээш хугацаагаар ажилласан тус газрын төрийн захиргааны 22 албан хаагчид 137.2 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгов. | |
| 2.1.3. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх. | | Батлагдсан 51 772 860.00 төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 42 209 761.74 төгрөгөөр буюу 94.5 хувиар биелүүлсэн. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын санд 51 772 860.00 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын газар нь 2024 оны орлогын төлөвлөгөө 56.7 тэрбум төгрөг оруулахаас хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 59.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлэн орлогын төлөвлөгөөг 105.4 хувиар давуулан биелүүлсэн. Төвлөрсөн сангийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт тухай бүрт төвлөрүүлж ажилласан. Нийгмийн даатгалын санд 59.8 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн нь 2023 оны мөн үетэй харьцуулбал орлого 10.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. | 100 |
| 2.1.4. | ЭМДЕГ-аас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн ажил олгогчийн шимтгэлийн | | ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна. | ЭМД-ын сангийн орлого 8 986 674.15 төгрөг төвлөрсөн байна. | ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө | Газрын даргын 2024 оны 03 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар ""Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх. | | | | 100 хувь биелсэн байна. | даатгуулагчийн шимтгэлийн орлогын 2024 оны төсвийн хуваарь”-ийг, 5 дугаар хавсралтаар ”Ажил олгогч, даатгуулагчийн төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын 2024 оны төсвийн хуваарь”-ийг тус ус баталж хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Нийгмийн даатгалын төвлөрсөн сангаас 11.0 тэрбум төгрөгийг ЭМДЕГазарт төвлөрүүлэн ажиллав. Эрүүл мэндийн даатгалд 15500 иргэд хамруулахаас 5759 иргэнийг хамруулсны 2561 нь малчин, 2628 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 570 нь оюутан байна. | |
| 2.1.5. | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх. | | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага оны эхнээс 57.41 хувиар өссөн байна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас доошгүй буурсан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай” 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/64 дүгээр тушаалын дагуу тус Нийгмийн даатгалын газрын “Авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай” 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/10 дугаар тушаалыг батлан хэрэгжилтийг ханган ажилааж байна. НДЕГ-ын даргын “Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг өрийг барагдуулах, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх аян зохион байгуулах тухай” 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/162 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 оны эхний үлдэгдэл 3.0 тэрбум төгрөг байсан нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 2024 оны эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 0.7 тэрбум төгрөгт хүргэж, оны эхнээс 212 аж ахуйн нэгж, байгууллагын 2.3 тэрбум төгрөгөөр буюу 76.6 хувиар бууруулж ажиллалаа. 2024 онд 1031 ажил олгогчийн нийгмийн даатгалын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шимтгэлийн авлагыг 2.0 тэрбум төгрөгт хүргэж бууруулж ажиллав. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах ажлын хүрээнд 91 аж ахуйн нэгж, байгууллагын арилжааны 12 банк дахь дансыг хааж, 49 аж ахуйн нэгж, байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 54 байгууллагатай шимтгэлийн авлага барагдуулах уулзалтын тэмдэглэл, 26 байгууллагатай харилцан тохиролцож авлага барагдуулах, хамтран ажиллах гэрээ байгуулж, шимтгэлийн өр авлага барагдуулах мэдэгдлийг 145 байгууллагад хүргүүлж, хуримтлагдсан авлагатай аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллаж буй ажилтанд үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг хязгаарлах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. Тус газар нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 899 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хянаж баталгаажуулан мэдээллийн санд оруулсан бөгөөд 313.2 тэрбум төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод 66.3 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж 64.3 тэрбум төгрөгийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлж ажиллав. | |
| 2.1.6. | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг барагдуулах | | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гарсан байна. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог хийсэн. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, өглөггүй байна. | Оны эхэнд сайн дурын даатгалын өглөг 117.9 сая төгрөг байсныг 100.2 сая төгрөгт хүргэн бууруулж баталгаажуулах, эзэн холбогдогчийг тодруулж ангилан бүртгэх ажлыг хийсэн. Тайлант хугацаанд сайн дураар даатгуулагчтай гэрээ хийхдээ тухай бүрт шимтгэлийн тооцоог хийж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өглөггүй ажиллаж байна. | |
| 2.1.7. | Бусад өглөг, авлагыг барагдуулах | | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар баталгаажсан байна. | а)Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах. б)Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах. | А.Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлага дансны 2023 оны жилийн эцсийн байдлаарх дэлгэрэнгүй судалгааг гарган сумдын нийгмийн даатгалын байцаагч нарт хүргүүлэн цаашид өр, авлага үүсгэхгүй ажиллах талаар нийгмийн даатгалын байцаагч нарын жилийн ажлын төлөвлөгөөнд тусган өр авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллав. Дээрх ажлын хүрээнд газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/23 дугаар тушаал гарган сумдын байцаагчдыг хуваарийн дагуу газарт ажиллуулж оны эхний бусад авлага 1218 дансны оны үлдэгдэл 478.0 сая төгрөг байсан бол 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 332.5 сая төгрөг болж 30 хувиар бууруулав. Оны эхний бусад өглөг 3303 дансны үлдэгдэл 355.0 сая төгрөг байсан бол 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 340.6 сая төгрөг болж 4 хувиар бууруулав. | 50 |
| 2.1.8. | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын газрын 2024 оны нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 56.7 тэрбум төгрөг оруулахаас хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 59.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлэн орлогын төлөвлөгөөг 105.4 хувиар давуулан биелүүлсэн. Төвлөрсөн сангийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлж, хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрт 148.3 тэрбум, тэтгэмжид 8.3 тэрбум төгрөгийг зарцуулав. Сангийн зарлага 2024 онд 157.0 тэрбум төгрөг батлагдсанаас 156.6 тэрбум төгрөгийг зарцуулж батлагдсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсвийг 0.4 тэрбум төгрөгөөр хэмнэж ажиллав. | |
| 2.1.9. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад 159 753 230.70 төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан. | а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу 159 753 230.70 төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. | Тэтгэмжийн даатгалын сангаас 2024 оны хүлээгдэж байгаа ажилгүйдлийн тэтгэмжийг 545 иргэнд 2624.7 сая төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 1395 иргэнд 459.9 сая төгрөг, Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 1285 иргэнд 4244.6 сая төгрөг, оршуулгын тэтгэмжийг 501 иргэнд 1002.0 сая төгрөгийг тус тус хуулийн хугацаанд шийдвэрлэж олгов. | 100 |
| 2.1.10. | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | Батлагдсан 1 595 036.80 төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу 1 501 485.23 төгрөг зарцуулсан. | а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх. б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | Газрын үйл ажиллагааны урсгал зардалд НДЕГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/201 дүгээр тушаалаар 2.1 тэрбум төгрөгийн зардлыг төсөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 2.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн хуваарийн дагуу 2.1 тэрбум төгрөг буюу 100% зардал, ангиллын дагуу зарцуулж, төсвийн сахилга, хариуцлагыг чангатган Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу өр үүсгэлгүй ажиллалаа. Батлагдсан бүтэц орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн хүний нөөц, үйл ажиллагаатай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн өр, бусад өр үүсгэлгүй зардал, ангиллын дагуу зарцуулан төсвийн сахилга, хариуцлагыг чанд мөрдөн ажиллалаа. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд сургалт, сурталчилгаа, хурал, зөвлөгөөнийг тухай бүрт цахим хэлбэрээр зохион байгуулж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллав. | |
| 2.1.11. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | НДС-ийн санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн тайлан, Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалын сангийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтлөх журмын дагуу нийгмийн даатгалын сангуудын болон байгууллагын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг 12 удаа гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газарт хугацаанд нь хүргүүлэв. Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг Green ERP программ ашиглан боловсруулж илгээсэн. | 100 |
| 2.1.12. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг | Нийгмийн даатгалын газрын даргын баталсан “Хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг байгуулах тухай” 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/16 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсгээс санх үүгийн тайланд бүртгэлтэй 116 нэр төрлийн 437 ширхэг 838.7 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгөд тооллого хийв. Үндсэн хөрөнгийн тооллогоор нийт тоологдвол зохих 437 ширхэг 838.7 сая төгрөгийн хөрөнгө дутагдалгүй тоологдсон. Үүнд: 147 ширхэг 100.6 сая төгрөгийн хөрөнгийн элэгдлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах; -Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх; -Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх; -Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн | хугацаа дуусч үлдэх өртөггүй, ашиглагдах хугацаа дуусаж цаашид ашиглах боломжгүй, эвдэрсэн 60 ширхэг 42.8 сая төгрөгийн хөрөнгүүд тус тус байна. Тооллогоор тоологдвол зохих хөрөнгө буюу балансад бүртгэлтэй хөрөнгийг эд хариуцагч нараар гарган картыг тулгахад хөрөнгийн нэр төрөл зөрсөн, картын бүртгэл нэр холилдож бичигдсэн зэргээс зөрүү үүссэн байсныг бүртгэлээр хяналт тавьж эзэнжүүлэх, эд хариуцагчаар салган бүртгэх ажилд гол анхаарлаа хандуулж ажиллалаа. Тооллогын комиссоос тооллогын дэлгэрэнгүй бүртгэлийг 1 дүгээр хавсралтаар, элэгдлийн хугацаа дууссан, үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгийг 2 дугаар хавсралтаар, актлах хөрөнгийг 3 дугаар хавсралтаар тус тус гаргав. Хөрөнгийн тооллогын ажлын хэсгээс ирүүлсэн актлах хөрөнгийн жагсаалтыг үндэслэн 2024 онд өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдуулж балансад бүртгэлтэй үлдэх өртөггүй, цаашид ашиглах боломжгүй, элэгдлийн хугацаа дууссан 13 нэр төрлийн 60 ширхэг 42.8 сая төгрөгийн хөрөнгийг актлах асуудлыг хэлэлцэн хурлын тэмдэглэл хөтөлж, гишүүдийн олонхийн саналаар дээрх хөрөнгүүдийг актлахаар шийдвэрлэж дүгнэлт гаргаж НДЕГазрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж ажиллав. Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлийг www.pcsp.gov.mn цахим хуудасны программ хангамжид мэдээллийг бүрэн оруулан ажиллалаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх; -Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах; -Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” програмд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах; -Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна. | | |
| 2.1.13. | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах. | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна. | 2023 оны нийгмийн даатгалын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймгийн Төрийн аудитын газарт хугацаанд нь хүргүүлэн шалгуулж өөрчлөлтгүй дүгнэгдсэн. | 100 |
| 2.1.14. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх. | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан. | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | А.Нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн орлого цуглуулах, тэтгэвэр тэтгэмж олгох үйлчилгээ үзүүлэх гэрээг Хаан банкны Төв салбар, Төрийн банк Төв аймаг салбаруудтай байгуулсан. Харилцагч банкуудаар 18.2 мянган тэтгэвэр авагч, 3.8 мянган тэтгэмж авагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй хүргэж ажилласан. Б.НДЕГазар болон банкуудын хамтран ажиллахаар байгуулсан гэрээний биелэлтийг заалт бүрээр дүгнэн НДЕГазарт хүргүүлсэн бөгөөд гэрээний заалт зөрчигдсөн заалтгүй ажилласан. | 100 |
| 2.1.15. | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг | а) Анхан шатны болон нягтлан бодох | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүр үнэн зөв бүрдүүлэх. | | оруулж бүртгэнэ. | тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу ажил гүйлгээг аккурэль болон мөнгөн сууриар бүртгэн хөтөлж, бүртгэлийн алдаа гаргахгүй хяналт тавьж ажиллан нэрийн дансны зөрүүний орлого орж ирэх үед тухай бүрт залруулга хийн ажилласан. Сумдын байцаагч, мэргэжилтнээс ирүүлсэн анхан шатны баримтыг газрын байцаагч, мэргэжилтнүүд мэдээллийн баазад оруулсны дараа шат дараалан хянаж баталгаажуулсны үндсэн дээр тэтгэвэр, тэтгэмж олгож байна. Газрын байцаагч, мэргэжилтнүүд бэлтгэсэн тэтгэвэр, тэтгэмж олгох жагсаалтыг хэлтсийн даргаар хянуулж, баталгаажуулсны дараа олгох ажлыг Санхүүгийн ажилтнууд зохион байгуулж ажилладаг. Нийгмийн даатгалын сангийн тайлан бэлтгэн холбогдох бүртгэлийн программуудад ахлах нягтлан бодогч, газрын даргын эрхээр программд хаалт хийж ажиллалаа. | |
| 2.1.16. | “Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн Core системыг нэвтрүүлэн нийгмийн даатгалын 3 банкны 5 сангийн банкны хуулгаар орлого, зарлагын гүйлгээг сар бүр таниулан мэдээллийн санд оруулж ажилладаг. Тухай бүр сангийн мэдээллийн системийн хөгжүүлэлттэй холбоотой ажлыг ирүүлсэн чиглэл, зааврын дагуу тухай бүрт шуурхай гүйцэтгэн ажиллав. Мөн НДЕГ-ын дарга Л.Мөнхзул болон Ай Ти Зон ХХК-ийн Төслийн баг тус газарт биечлэн ирж ажиллаж, мэдээллийн системийг ашиглахад үүсч буй нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тодорхой асуудлуудыг шийдвэрлэж, зөвлөн туслав. | |
| 2.1.17. | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан. | а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | А.Үйл ажиллагааны батлагдсан зардал, бүтэц, орон тооны хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажилласан бөгөөд тайлант хугацаанд өр, авлага үүсгэлгүй ажилласан.<br>Б.Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, өглөгийн үлдэгдлийг улирал бүрээр тооцоо нийлэн баталгаажуулан ажиллаж байгаа бөгөөд сангуудын бусад авлага, өглөгийн бүртгэлийг нягтлах, эзэн холбогдогчтой тооцоо нийлэх барагдуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийгмийн даатгалын сан болон байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр нь баталгаажуулан ажилладаг ба баталгаажуулсан тайланг холбогдох хавсралтын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газарт хуваарийн дагуу хүргүүлэв. | 100 |
| 2.1.18 | ЭМД-ийн шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчтай холбоотой өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ЭМДЕГ-т хүргүүлэхтэй холбоотой холбогдох ажлуудыг хэрэгжүүлэх | | Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл болон тайлангаар гарсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Харилцах дансны үлдэгдэл болон санхүүгийн тайлангаар баталгаажуулсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан. | а) ЭМД-ын харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн | А.Эрүүл мэндийн даатгалын харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл нийт 43.6 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж төвлөрүүлсэн.<br><br>Б.Эрүүл мэндийн даатгалын харилцах дансанд 2023 он ба түүнээс өмнөх онуудад 3303-аар бүртгэсэн 273 даатгуулагчийн төлсөн 17.7 сая төгрөгийн шимтгэлийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан жагсаалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байна. 3903 дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т ирүүлсэн байна. в) 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т ирүүлнэ. | | |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | | | | | | | |
| 3.1.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан. | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг тавих журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Зөвлөмж хүргүүлэх тухай” 05 дугаар сарын 01-ний өдрийн 01/899 дугаар албан бичгийн дагуу Газрын даргын ”Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2024 оны 05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 17-ны өдрийн А/08 дугаар тушаалаар тус газрын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, мэдээлэл байршуулах, хяналт тавих үүрэг бүхий албан хаагчийг томилон, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Тус газрын **tuv.ndaatgal.mn** цахим хуудсанд болон **shilen.gov.mn** шилэн дансны цахим хуудаст байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл, ил тод байдлын мэдээлэл, цаг үеийн мэдээллийг тухай бүрт нь шинэчлэн байршуулж байна. Мөн газрын “Төв аймгийн Нийгмийн даатгалын газар” гэсэн фэйсбүүк хуудсанд 251 мэдээллийг байршуулж иргэд, даатгуулагчдад мэдээллийг шуурхай хүргэн ажилласан. | |
| 3.1.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2023 оны байдлаар 95.7 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. | **Нийгмийн даатгалын сан:** 2024 оны 11 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 155 мэдээлэл байршуулахаас 118 мэдээллийг хугацаанд нь, 28 мэдээллийг мэдээллээгүй, 9 хугацаа хоцроож мэдээллэж, хуулийн хэрэгжилт 76.1 хувьтай байна. Үүнээс хугацаанд нь байршуулсан 118 мэдээллээс хугацаанд нь байршуулсан 48, оруулах мэдээлэл байхгүй 70, мэдээлэл оруулаагүй 28 байна.<br>**Үйл ажиллагаа:** 2024 оны 11 дүгээр сарын байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 166 мэдээлэл байршуулахаас 17 мэдээллийг хугацаа хоцроож, 118 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээллийг байршуулаагүй, хэрэгжилт 79 хувьтай байна. Үүнээс хугацаанд нь | 75 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байршуулсан 71.4 хувь байна. Үүнээс хугацаанд нь байршуулсан 118 мэдээллээс хугацаанд нь оруулсан 33, оруулах мэдээлэл байхгүй 85, мэдээлэл оруулаагүй 31 байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 73.7 хувь биелэлттэй байна. | |
| Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах | | | | | | | |
| 3.2.1. | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | Шаард-лагагүй | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | Илэрсэн төлбөр зөрчлийн 72,6 хувийг барагдуулж ажилласан. | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Тус газрын 2024 оны Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу нийт 171 ажил олгогч, 8 суманд хяналт шалгалт хийхээс Архуст, Мөнгөнморьт, Эрдэнэ сумдад хяналт шалгалт хийж 26 ажил олгогчийг шалгалтад хамруулж Нийгмийн даатгалын хууль зөрчсөн зөрчлийг илрүүлэн 8 ажил олгогчид 3.6 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, төлбөрийг бүрэн барагдуулсан. 2022, 2023 онд шинээр тогтоогдсон 175 тэтгэвэр авагчийн тогтоолт, олголтод хяналт шалгалт хийж 19 хувийн хэрэгт зөрчил илрүүлснээс 5 тэтгэврийг зогсоож, ажилласан хугацааг илүү, дутуу оруулснаас 5 тэтгэвэр авагчид 9.1 сая төгрөг илүү олгосныг төлүүлэх, 8 тэтгэвэр авагчид 1.8 сая төгрөг дутуу олгосныг нөхөн олгохоор улсын байцаагчийн акт тогтоов. Бусад тэтгэврийн хувийн хэрэгт зөрчил илрээгүй. Шалгалтын хугацаанд 27 ажил олгогчийн 118.5 сая төгрөгийн шимтгэлийн өр төлбөрөөс 8 ажил олгогчийн 25.4 сая төгрөгийн өрийг барагдуулж, 5 ажил олгогчид өр авлага барагдуулах хугацаатай албан шаардлага өгч ажиллалаа. Сангийн бусад өглөг, авлага шалгах ажлын хүрээнд 27.5 сая төгрөгийн өглөг, 22.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тулгахад 4.8 сая төгрөгийн авлага хаах байтал өглөгөөр бүртгэснийг нягтлан бодох бүртгэлийн залруулга бичилт хийж зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллахыг сангийн мэргэжилтэн, сумын байцаагч нарт зөвлөмж өгч ажиллалаа.<br>2.Өргөдөл, гомдол, аж ауйн нэгж байгууллагын хүсэлтийн дагуу 125 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн 72 байгууллагын холбогдох бичиг баримтыг шалгаж нийт 26.1 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, 11.8 сая төгрөгийн алданги ногдуулснаас 23.6 сая төгрөгийн акт, 8.5 сая төгрөгийн алдангийн төлбөрийг тус тус барагдуулж 84.3 хувь биелэлттэй байна.<br>3.Шинээр тогтоогдсон болон шилжиж ирсэн 1255 тэтгэврийн тогтоолтод хяналт шалгалт хийж 328 тэтгэврийн тооцооллын болон баримт бичгийн зөрчлийг илрүүлэн нөхөн бүрдүүлэлт хийж, баримтын зөрчлийг арилгуулж тэтгэвэр тогтоох, олгох нөхцлийг бүрдүүлж ажиллалаа.<br>4.Шинээр тогтоогдсон тэтгэмжийн тогтоолтод хяналт шалгалт хийж ажилгүйдэл 545, Жирэмсний болон амаржсаны тэтгэмж 1285, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж 501, хөдөлмөрийн чадвар алдсаны 1395 тэтгэмжийн тогтоолтыг хянаж, 158 тэтгэмж авагчийн тооцооллын болон тэтгэмж авах эрх үүсээгүй зөрчлийг илрүүлэн зөрчлийг арилгуулж тэтгэмж авах нөхцлийг бүрдүүлж ажиллалаа.<br>5.НДЕГазрын Хяналт шалгалтын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 1995-1997 онуудад хугацаат | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэргийн алба хаасан 519 албан хаагчийн регистрийн дугаарын мэдээллийг нийгмийн даатгалын нэгдсэн сан, улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас шүүлт хийж бүртгэлжүүлж судалгааг НДЕГ-т хугацаанд нь хүргүүлэв.<br>6.Газрын даргын баталсан Төлөвлөгөөний дагуу “Малчин даатгуулагчид тэтгэвэр, тогтоохойд баримтлах журам”, “Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох орон тооны бус зөвлөлийн дүрэм”-ийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар орон тооны бус зөвлөлд хандаж өргөдөл гаргасан нийт 51 иргэний тэтгэврийн хувийн хэрэг, баримт бичгийг нягтлан шалгаж 2 тэтгэвэр авагчийн тэтгэврийг зогсоож, 5 тэтгэвэр авагчийн тушаал шийдвэрийг нягтлан шалгахаар архивын лавлагаа авахаар хүсэлт явуулж, зарим баримт бичгийг нэмж бүрдүүлэхээр зөвлөмж өгч ажиллав. | |
| 3.2.2. | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэж дүгнэх, | Шаард-лагагүй | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг хагас, бүтэн жилээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас гаргуулан авч нэгтгэж дүгнэх, | Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан. | Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажиллах | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд тухайн байгууллагын даргатай холбогдож дээрх санамж бичгийг танилцуулсан боловч санхүүгийн баримт нууцлалтай гэсэн байдал тайлбар өгсөн тул хяналт шалгалт хийх боломжийг олгоогүй болно. | 100 |
| 3.2.3. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн | | 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд ҮОМШӨ-ний сангийн зарцуулалтад | | ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, | Тус газрын 2021-2023 оны үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх | | хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнд хяналт тавьж ажиллах, | - | зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд шалгаж, илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах | сангийн үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалт газраас хийгдсэн шалгалтаар тэтгэмжийн тогтоолт, олголт, 43 тэтгэврийн хувийн хэргийг шалгуулсан. Шалгалтаар 3 тэтгэвэр авагчийн оношийн шифр буруу, хувь хэмжээ заалт зөрүүтэй зөрчлийг илрүүлж зөрчлийг арилгуулсан. Тэтгэврийн дутуу олголт 6.9 сая төгрөг, илүү олголт 1.3 сая төгрөг, тэтгэмжийн дутуу олголт 6.2 сая төгрөг, тэтгэмжийн илүү олголт 2.0 сая төгрөг, ҮОМШӨДаатгалын сангаас тэтгэмжийн даатгалын санд залруулга гүйлгээ хийх 2.7 сая төгрөг, үйлдвэрлэлийн ослын хувь хэмжээ буруу тооцсон 2.1 сая төгрөгийн төлбөр зөрчилд УБАкт тус тус тогтоож 16.4 сая төгрөгийг барагдуулж ажиллав. Тэтгэврийн тогтоолтын хуудас хэвлээгүй, үйлдвэрлэлийн ослын актыг хувийн хэрэгт хавсаргаагүй, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд тогтоолтын хуудсыг хэвлээгүй, хүүгийн орлого бүртгэл буруу, өглөг авлага өссөн, амь даатгал зардалд оруулж олголт хийсэн, сургалтын зардал олголт баримт бүрдүүлэлт дутуу зэрэг илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллалаа. | |
| 3.2.4. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх | | Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор , гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | - | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, ирэлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах | Асуудал хариуцсан албан хаагч хүүхэд асрах чөлөөтэй байгаа тул нийгмийн хамгааллын хяналтын байцаагчийн үүрэгт ажлыг хяналт шалгалтын байцаагчаар хавсруулан гүйцэтгүүлж байна. Төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд Төв АЗЗА ТӨХК, Төв Чандмань ДЭХГазар, Номин тав трейд ХХК-иудын санхүүгийн баримт анхан шатны баримтыг шалгаж эрсдлийг үнэлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Баримтын шалгалтаар гэрээгээр гүйцэтгэсэн цалин хөлснөөс НДШ тооцож төлөөгүй зөрчилд 7.6 сая төгрөгийн акт тогтоож төлбөр зөрчлийг 100 хувь барагдуулж ажиллав. Мөн Дэлхийн зөн олон улсын байгууллагын сүүлийн 6 жилийн цалин хөлсний санхүүгийн баримтад хяналт шалгалт хийхэд аливаа зөрчил илрээгүй байна. | |
| 3.2.5. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/50 дугаар тушаалаар баталсан “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын дагуу цахим мэдээлэлд тулгуурлан хийх хяналт, шалгалтыг тогтмолжуулах, | | Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”-(http://10.9.0.5/monitoring)-д тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд цахим хяналт, шалгалтыг тогтмолжуулж, илэрсэн зөрчлийн 80,0 доошгүй хувийг шалгаж, залруулсан. | Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”-(http://10.9.0.5/monitoring)-аас тодорхой өгөгдлийн дагуу шүүлт хийж, зөрчилтэй байх магадлалтай мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шалгаж шийдвэрлэсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/50 дугаар тушаалаар баталсан “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын хянал тшалгалт хийгдээгүй. Программ хангамж нэвтрээгүй болно.<br><br>(Үнэлэх боломжгүй) | 0 |
| 3.2.6 | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн | | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, | | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70- | Хяналт шалгалтын тайлан, мэдээг улсын байцаагчийн актад үндэслэн гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. 2024 оны хяналт шалгалтын тайлангаар урд оны үлдэгдэл 108.8 сая төгрөгийн актын үлдэгдэл дээр шинээр 41.9 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож 67.9 сая төгрөгийг барагдуулж, 82.8 сая төгрөгийн улсын байцаагчийн актын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх, | | зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт хүргүүлнэ. | | аас доошгүй хувийг барагдуулсан байна. | төлбөр зөрчлийн үлдэгдэлтэй байна. **Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас:** нийгмийн даатгалын санд шалгалт хийж тогтоосон улсын байцаагчийн актын үлдэгдэл 7.8 сая төгрөгөөс 1.6 сая төгрөг буюу 20.5 хувийг барагдуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас шалгаж тогтоосон хуурамч баримт бичиг бүрдүүлж тэтгэвэр тогтоолгон авсан 14 иргэний 160.5 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлж 9 тэтгэвэр авагчдад газрын хяналт шалгалтын байцаагчид 107.6 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож 89.3 сая төгрөгийг барагдуулж ажиллалаа. Дээрх улсын байцаагчийн актын төлбөр зөрчлөөс 4 тэтгэвэр авагчид холбогдох 18.3 сая төгрөгийн үлдэгдлийг тэтгэврээс нь сар бүр суутгал хийж барагдуулж ажиллав. **Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр:** Нийгмийн халамжийн санд хяналт шалгалт хийж 49 иргэнд илүү олгосон 8.6 сая төгрөгийн тэтгэврийг буцаан төлүүлэх улсын байцаагчийн акт тогтоож 1.6 сая төгрөгийг барагдуулж, улсын байцаагчийн актын биелэлт 18.6 хувьтай байна. Аудитын газраас 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийж: 0.5 сая төгрөгийн акт-1, албан шаардлага-1, зөвлөмж-2 тус тус өгөгдсөн. Актын төлбөр зөрчлийг бүрэн барагдуулж, албан шаардлагын хариуг хугацаанд нь хүргүүлж ажилласан. | |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Төсвийн Ерөнхийлөн захирагч болон Төв аймгийн Засаг даргын хооронд байгуулсан хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилтийн гэрээний биелэлт, Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт болон бусад ажил үйлчилгээний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж, цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлж ажиллалаа. | 100 |
| 4.1.2. | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Тайлант хугацаанд Засгийн газрын "Иргэд олон нийттэй харилцах төв"-д нийгмийн даатгалын үйлчилгээтэй холбоотой 10 гомдлыг хүлээн авч шийдвэрлэн иргэн, даатгуулагч, тэтгэвэр авагчдад албан тоотоор шийдвэрлэлтийн хариуг хүргүүлэн ажилласан. Тэтгэмжийн үйлчилгээ цахимжуулсантай холбоотой ажил олгогчийн нягтлан бодогчоос шимтгэлийн цахим системээр мэдээллийг ирүүлээгүй асуудлыг нягтлан шалгаж удирдлага арга зүйгээр хангаж ажилласан. Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 529 албан бичиг, хүсэлтийг хүлээн авснаас хуулийн хугацаанд нь багтааж 499 асуудлыг шийдвэрлэн хариу өгсөн, 30 асуудлыг шийдвэрлэх хуулийн хугацаа болоогүй хүлээгдэж байна. 249 өргөдөл гомдол хүлээн авсан бөгөөд төрлөөр авч үзвэл:<br>1. Хүсэлт-239 буюу 95.9% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Гомдол-10 буюу 4.1%<br>249 өргөдлийг утгаар ангилан авч үзвэл:<br>1.НДШ-ийн асуудлаар- 61 буюу 24.8%<br>2.СДД-ын асуудлаар -39 буюу 15.6%<br>3.Бусад асуудлаар- 21 буюу 8.4%<br>4.Тэтгэвэртэй холбоотой асуудлаар- 45 буюу 18%<br>5.МХШЗ-ийн асуудлаар- 10 буюу 4%<br>6.Тэтгэмжтэй холбоотой асуудлаар- 28 буюу 11.2%<br>7.ЭХМК-ын асуудлаар- 9 буюу 3.6%<br>8.ЭМД-ын асуудлаар- 29 буюу 11.6%<br>9.Нөхөн даатгал-7 буюу 2.8% хүлээн авч 225 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн бол 24 өргөдлийн шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа болно. | |
| 4.1.3. | Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх. | | Нийгмийн даатгалын хэлтэс дотооддоо болон хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна. | Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн. | Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна. | Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу газрын болон сумдын байцаагч нар нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, сангийн харилцахын баримт, сайн дурын даатгалын гэрээ, зогсоогдсон тэтгэврийн хувийн хэрэг зэрэг баримт бичгийг хуульд заасны дагуу 2024 оны 1 дүгээр улиралд багтаан хүлээлгэн өгч, архивын хадгаламжийн нэгж үүсгэв. НДГазрын даргын 2023 оны А/03 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, газрын архивт хадгалагдаж байгаа санхүүгийн баримтыг нягтлан шалгах, эмхлэн цэгцлэх, хадгалах, устгах, хамгаалах ажлыг зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд устгах хэргийн жагсаалтыг гарган дээд шатны байгуулагад хүргүүлэв. Тус газар 2024 онд даатгуулагчид 1203 шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолт гаргаж өгөх үйлчилгээг үзүүлсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.4. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах. | | Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байна. | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт улирал бүр тайлагнасан байна. | Тус аймаг 27 сумтай, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын гүйцэтгэлийн чанар, үйлчилгээг сайжруулах зорилгоор НДЕГ-ын даргын “Бүтэц орон тоо батлах тухай” 2024 оны А/51 дүгээр тушаалаар 55 орон тоогоор шинэчлэн баталсан. Шинээр болон ажил хавсран гүйцэтгэгчээр томилогдсон 7 албан хаагч, өөр ажилд шилжсэн болон ажлаас чөлөөлөгдсөн 5 албан хаагчтай холбоотой тушаал, шийдвэрийг Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зүйл, заалтыг үндэслэн гаргасан. Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасны дагуу зэрэг зэвийн нэмэгдэл олгохоор аймгийн Засаг даргын 2024 оны Б/03 дугаар захирамжийн дагуу 5 байцаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг тооцож олгосон. Мөн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн цахим систем”-д газрын албан хаагчдын хөдөлгөөнийг тухай бүрт шинэчилэн баяжуулж, Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч, Бичиг хэрэг, дотоод асуудал, хөрөнгө хариуцсан мэргэжилтэн, Тэтгэмжийн тогтоолт олголт хариуцсан байцаагч, мэргэжилтэн, Эрдэнэ, Баян, Өндөрширээт, Батсүмбэр, Баяндэлгэр сумдын Нийгмийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даатгалын байцаагчийн сул орон тоог тус тус зарлуулж, төсвийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, архивын ажилтны ажлын байрыг нийтэд зарлаж, шаардлага хангасан албан хаагчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу томилсон болно. | |
| 4.1.5. | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх. | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Монгол Улсын Засгийн газраас зарласан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх, олон нийтэд таниулах, сурталчлах “Ногоон-Сэргэлт, Ногоон-Төв аймаг” бүх нийтээр мод тарих сарын аяны хүрээнд “Баатаруудын цэцэрлэгт хүрээлэн”-нд тэхийн шээг нэр төрлийн 10 ширхэг мод тарьсан. Нийгмийн даатгалын газар нь гадна талын талбайн хагарч эвдэрсэн болон Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үүд хэсгийн шатыг цементлэн засварлаж, газрын дотоод тохижилтийг сайжруулж цэцгүүдийн ваарыг шинэчилж, мандлын цэцэг тарьсан. Байгууллагын барилгын гаднах хаягийг крилл болон монгол бичгээр шинэчлэн хийлгэсэн. Мөн газрын албан хаагчдад чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулан ширээний теннис, дартс тоглох нөхцлийг бүрдүүлж ажиллав. "Өв соёлоо эрхэмлэж үндэсний бичгээ сурцгаая-2025" аян өрнүүлэн, төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлж, төрийн албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөх ажлыг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын зайн ДИНАМИК системээр 42 байцаагч Монгол бичгээр бичих ур чадварын сургалтад 7 хоног тутамд нэг удаа хамрагдан бичих ур чадвараа дээшлүүлэн суралцаж байна. Монгол улсын Загийн газрын 2020 оны 96 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3”, Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 165 дугаар тогтоол, аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Засаг даргын Тамгын газрын хуулийн хэлтсийн дэргэдэх Архивын тасгийн даргаар ахлуулсан ажлын хэсгээс тус газрын захиргааны албан хаагчдаас монгол бичгийн түвшин тогтоох 20 асуулт бүхий шалгалтыг тестээр авч, монгол бичгийн ур чадварын үнэлгээ, шалгалтын дүнгээр 46 оноо авч мэдлэг чадвараа дээшлүүлэх, сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлт өгсөн. Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын 1-р шатыг хэрэгжүүлж, төсөвлөлт, бичил төслийг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор газрын албан хаагчдын дунд Оюунлаг эмэгтэйчүүд, Илүүдэл жингүй-эмэгтэйчүүд төслүүдийг хэрэгжүүлж байна. Нийгмийн салбарын байгууллагуудын нэрэмжит 4 төрөлт спортын тэмцээнд амжилттай оролцож, эрэгтэй сагсан бөмбөгийн төрөлд хүрэл медаль, эмэгтэй теннисийн төрөлд хүрэл медаль тус тус хүртлээ. Мөн шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ДААТГУУЛАГЧДЫН ӨДӨР”-ийн нэрэмжит Волейболын тэмцээнийг 2024 оны 04 дүгээр 13-ны өдөр зохион байгуулж, нийт 24 байгууллагын 36 баг, тамирчид оролцсон байна. Байцаагч, ажилтнуудын харилцаа, хандлага, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлийн хүрээнд газрын залуучуудын зөвлөл, байцаагч нарын хамтран санаачилж зохион байгуулсан АХА асуулт хариултын тэмцээн, дартсын тэмцээн, талархлын аян зэрэг арга хэмжээнд хамт олныг бүрэн хамруулж амжилттай оролцож байр эзэлсэн албан хаагчдыг шагнаж урамшуулав. Мөн. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдөр зохион байгуулсан гамшгаас хамгаалах “Команд штабын сургууль”-д амжилттай оролцов. | |
| 4.1.6. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах. | | Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хანган, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна. | Газрын даргын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталж, 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/15 тушаал, 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/32 дугаар тушаалаар уг журамд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хөдөлмөрийн дотоод журмаар 2024 онд газрын 3 албан хаагчдад 700.0 мянган төгрөгийн тэтгэмж, тусламж үзүүлээд байна. “Жендэрт суурилсан хүчирхийлэл” сэдэвт сургалтад газрын 3 албан хаагчийг цахимаар, 1 албан хаагчийг ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээний сургалтад цахимаар, удирдлагын академиас зохион байгуулсан төрийн албан хаагчийн анхан шатны мэргэшүүлэх сургалтад 1, төрийн албан хаагчийн дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагч, богино хугацааны сургалтад 1 албан хаагчийг тус тус хамруулсан. Мөн газрын дэргэдэх Эцэг эхийн зөвлөл нийт албан хаагчдын 0-18 насны 105 хүүхдийн судалгааг гарган, "Хүүхдийн баяр"-ыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэмдэглэн өнгөрүүлж гарын бэлэг гардууллаа. | |
| 4.1.7. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаанда а мөрдөж ажиллана. | Нийгмийн даатгалын газрын хэмжээнд ХАСХОМ гаргах нийт 35 албан хаагчийн мэдүүлгийг хугацаанд нь гарган баталгаажуулав. 2024 онд улсын байцаагчийн эрх шинээр авсан 3 байцаагч, шинээр ажилд томилогдсон 5 байцаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хянуулж томилсон. Монголын улсын Төрийн албаны зөвлөлөөс 2024 оны 5 дугаар сарын 01, 11 дүгээр сарын 25-ны өдөр тус тус аймгийн Төрийн байгууллагын албан хаагчдад Төрийн албаны салбар зөвлөлийн уялдаа холбоо, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 3 чиглэлээр сургалт зохион байгуулж, газрын 18 албан хаагч, аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс шинээр тангараг өргөсөн албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалт зохион байгуулахад 5 албан хаагчийг тус тус хамруулсан. “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт дотоодын сургалтыг 11 дүгээр сард газрын нийт байцаагч, ажилтнуудад зохион байгуулж ажиллав. | 100 |
| 4.1.8. | Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах | | НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” | - | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг | Газрын байрны гаднах болон дотоод хаяг, гэрчилгээ, батламж, хавтасны хаяг, нэрийн хуудас, салбарын болон аймгийн урианы жилийг монгол кириллээр зэрэгцүүлэн хөтлөн ажиллаж байна. “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн "Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт" батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөж ажилласан байна | | сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажилласан байна. | хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS 6395:2022, "Төрийн албан хаагчийн нэрийн хуудсанд тавих ерөнхий шаардлага" MNS 6978:2022, "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага" MNS 5283:2022, "Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо. Тооцоолох хэрэгслийн гарын товчлуур дээрх монгол бичгийн үсэг, тэмдгийн байршил" MNS 7004:2023 стандартуудыг албан ажлын хэрэгцээнд худалдан авч, өдөр тутмын хэрэглээнд ашиглаж байна. | |
| Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 4.2.1. | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | | Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх …. удаагийн сургалтад ...... албан хаагчийг хамруулсан. | -Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт зохион байгуулна.<br>-Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ. | 2024 онд нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудад дотоодын сургалтыг цахимаар 14 удаа, танхимаар 3 удаа, Нийгмийн даатгалын ерөнхий газраас цахимаар 15 удаа зохион байгуулсан сургалтад байцаагчдыг хамруулж, хуулийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн ажилласан. Тухайлбал 2024 оны 7, 11, 12 дугаар сард 24 сумын 27 байцаагч ажилтанд чиглүүлэх сургалтыг зохион байгуулж, нийгмийн даатгалын багц хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын талаар албан хаагчдад нэгдсэн ойлголт өгөх, нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулсан болно. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж байгаа "Асуудал, шийдэл" сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд сургалт, сурталчилгаа, мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Төрбат, Тэтгэмжийн байцаагч С.Ариунтөгс, Тэтгэврийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байцаагч Б.Доржготов нар оролцов. Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс шинээр тангараг өргөсөн албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалт зохион байгуулахад 5 албан хаагчийг тус тус хамруулсан. Тус газраас төрийн албанд шинээр томилогдсон 8 албан хаагчид шинэ албан хаагчийн “Чиглүүлэх болон дасан зохицох хөтөлбөр’’-т хамруулж, ажлын байранд нь мэргэшүүлэн ажиллуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллав. | |
| 4.2.2. | Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах; | | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн .... удаагийн сургалтад ......... иргэд, даатгуулагчийг хамруулсан. | Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна. | Нийгмийн даатгалын багц хууль, нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд 2024 онд нийт 154 удаагийн сургалт, сурталчилгааны арга хэмжээ кохион байгуулж, эдгээр арга хэмжээнд нийт 173 ажил олгогч, 5529 даатгуулагч иргэдийг хамруулав. Тухайлбал: аймгийн Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран “Нээлттэй хаалганы өдөрлөг”, “Нийгмийн салбарын явуулын үйлчилгээ” арга хэмжээг Алтанбулаг, Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Баянцогт, Заамар, Эрдэнэ, Эрдэнэсант сумын 897 иргэд, даатгуулагчдад, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран “Малжуулах төсөл”-ийн хүрээнд 23 сумын 1200 гаруй иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын багц хууль, сайн дурын даатгалын талаар сургалт зохион байгуулж, мэдээлэл хүргэж ажиллав. Мөн аймаг, сумын багийн иргэдийн нийтийн ээлжит 36 удаагийн хуралд оролцож 1695 даатгуулагчид, 51 ажил олгогч, байгууллагын 1350 албан журмын даатгуулагчийг тус тус хамруулсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна.. Мөн байгууллагын фэйж хуудсанд 3 удаагийн видео контент бүтээж иргэд даатгуулагчдад түгээсэн. Түүнчлэн Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга, үйлчилгээний талаар 25 постер мэдээлэл, 13 төрлийн үйлчилгээний гарын авлага боловсруулан хэвлүүлж нийтдээ 6500 орчим гарын авлага, тараах материал түгээн, сургалт сурталчилгаанд ашигласан байна. Дээрх арга хэмжээг үе шаттай зохион байгуулсны үр дүнд 2023 онд нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчдын тоо 5150 байсныг 2024 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 5250 буюу өмнөх оноос 100 даатгуулагч буюу 2 хувиар өссөн байна. | |
| 4.2.3. | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах; | | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл,<br>Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д байршуулсан мэдээллийн тоо, хандалтын тоо.<br>Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн ....... тоо, мэдээллийн төрөл..... | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. | Нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлт, шинээр хэрэгжиж буй хууль тогтоомж болон цахим нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тайлант хугацаанд “Төв аймгийн нийгмийн даатгалын газар” фэйж хуудсанд 3 удаагийн видео контент бүтээж иргэд даатгуулагчдад түгээсэн. Түүнчлэн Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга, үйлчилгээний талаар 25 постер мэдээлэл, 13 төрлийн үйлчилгээний гар ын авлага боловсруулан хэвлүүлж нийтдээ 6500 орчим гарын авлага, тараах материал түгээн, сургалт сурталчилгаанд ашигласан байна. Газрын фэйсбүүк хуудсаар дамжуулан нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 251 удаагийн зар, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цахим хичээл, постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл | | ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна. | мэдээллийг тухай бүрт иргэд даатгуулагчдад хүргэж, tuv.ndaatgal.mn газрын цахим хуудсанд Засгийн газрын 143 дугаар тогтоолоор баталсан “Мэдээллийн ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу мэдээллийг шинэчилж, баяжилтыг хийн ажиллаж байна. | |
| Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх | | | | | | | |
| 4.3.1. | Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах | | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна. | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга хэмжээ авсан байна. | Нийгмийн даатгалын багц хууль 2024.01.01-ний өдрөөс хэрэгжиж байгаатай холбогдуулан тус газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь Эрүүл мэндийн магадлалын зөвлөл болж өөрчлөгдөж, НДЕГ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/60 дугаар тушаалаар зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн байгуулагдсан. Тус газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь 2024 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 50 удаа 398 цаг хуралдаж 2224 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэлэлцсэн бөгөөд үүнээс 276 хүний ХЧА-ыг шинээр тогтоосон, 1598 хүний ХЧА-ын хугацааг сунгасан, 180 иргэнийг ХЧА-ыг цуцалсан, 115 иргэний ХЧА-ын хувь хугацааг өөрчлөн тогтоосон, 2 хүний хөдөлмөрийн нөхцөл сольсон, 1 хүний ажлын цаг хорогдуулсан, 52 хүнийг буцаасан байна. 2024 оноос Засгийн газрын 448 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан Эрүүл мэндийн магадлалийн зөвлөлийн дүрмийг баримтлан иргэд, даатгуулагчдын ХЧА-ын асуудлыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлэлцэн шийдвэрлэж байгаа бөгөөд иргэдийг заавал биеэр ирүүлэхгүйгээр амбулаторийн үзлэгийн карт, холбогдох баримт бичигт үндэслэн хэлэлцэн шийдвэрлэж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 01/1140 “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн хүрээнд 0-18 настай хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон хүүхдийн тоо 33 байна. Үүнээс: Хөгжлийн бэрхшээлтэй Хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1 дэх заалтыг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа дууссан өдрөөс 5 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисст шилжүүлэв. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс хийсэн “Дахин магадлан” шалгалтанд хамрагдвал зохих 318 иргэнийг 100 хувь хамруулах ажлыг зохион байгуулж, хурлын дотоод үйл ажиллагаа “Хэвийн” үнэлгээтэй шалгуулав. Магадлалын үйл ажиллагааг боловсронгуй болгох иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх ажлын хүрээнд хурлын үйл ажиллагааг аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх төв “Аз жаргалын өргөө”-нд зохион байгуулж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хагас жил тутам тулгалт хийсэн байна. | | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд жилд 2 –оос доошгүй удаа тулгалт хийж зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажилласан байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв хийж батлуулсан ба 2022, 2023 он, 2023-2026 оны төсвийн төсөөллийн саналыг боловсруулж хугацаанд хүргүүлсэн. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан 1 иргэний өргөдөл, баримт бичгийг хүлээн авч ор хоногийн зардал, унааны зардал 648.0 мянган төгрөгийн олгосон. ЭММЗ-ийн хурлын жагсаалтыг тухай бүр архив үүсгэн хадгалж байна. | 100 |
| 4.3.2. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байх | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг хагас жил тутам зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 2024, 2025 оны төсвийн төсөөллийн тооцоог хийж хугацаанд нь хүргүүлэв. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан нийт хүний тоо 2806, үүнээс ердийн өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдсан хүний тоо 2769, үйлдвэрлэлийн ослоор хөдөлмөрийн чадвар алдсан 37 хүн байна. Нийт хугацаагүй заалтаар сунгагдсан хүний тоо 515 даатгуулагч, хүнийг сумын эрүүл мэндийн төвийн эмчийн хяналтанд хүлээлгэж өгөх, эмнэлгийн хувийн хэргийг шилжүүлэх ажлыг зохион байгуулав. Эрүүл мэндийн магадлалын асуудлаар ирсэн 59 албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг хүргүүлсэн. | 100 |
| | | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил | Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177, А/433 дугаар хамтарсан тушаал “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”–ын хэрэгжилтийг хангаж ажиллах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | доошгүй удаа зохион байгуулсан байна. | | мэргэжилтний үзлэгийг зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадвар сайжирч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаа ижил түвшинд хүрсэн байна. | хүрээнд Аймгийн нэгдсэн эмнэлэг, 27 сумын Эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад албан бичиг хүргүүлэв. Мөн Аймгийн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасгийн эмч мэргэжилтнүүдэд нийгмийн даатгалын багц хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн талаар 2 удаагийн сургалт хийж, уг арга хэмжээнд 31 хүнийг хамруулсан. Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 1 удаа зохион байгуулав. | |
| 4.3.3. | Эрүүл мэндийн магадлалын оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн хэрэгжилтийг хангаж ажиллах | | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллана. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн болон судалгааны тайланг ЭММТЗ-д хүргүүлнэ. | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах төлөвлөгөө гарган, хэрэгжүүлсэн байна. | Тайлант хугацаанд ХЧТА-ын эмнэлгийн хуудас 509, Жирэмсний болон амаржсаны 617, нийт 1126 эмнэлгийн хуудсыг цахимаар хүлээн авч оношийн үндэслэл, бичилт олголтын байдлыг цахим баримтад тулгуурлан шалгаж, хугацаа хоцроосон, 11 кодтой, мөн бичилтийн алдаатай буруу илгээгдсэн 6 эмнэлгийн хуудсыг буцаасан. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны 2023 оны 5 баримт бүрдүүлэн архивт хүлээлгэж өгөв. ЭММЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, дахин магадлалд хамрагдах ажлын бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. | 100 |
| | | | Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгаа хийж, тодорхой арга хэмжээ авч орон нутгийн удирдлага, | | Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгааг хийж дүгнэсэн | Аймгийн хэмжээнд нийт хөдөлмөрийн чадвар алдсан хүний тоо 3068, улсын дундажтай харьцуулахад 3.1 хувьтай байна. Өвчлөлийн шалтгаанаар сэтгэцийн эмгэг 819 тохиолдлоор 29.1% , гэмтэл согогийн өвчин 411 тохиолдлоор 14.6%, нүдний өвчин 379 тохиолдлоор 13.5% , дотрын өвчин 367 тохиолдлоор 13%, мэдрэлийн өвчин-359 тохиолдлоор | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох байгууллагад танилцуулсан байна. | | байна. | 12.7% буюу нийт өвчлөлийн 83%-ийг ээлж тэргүүлэх шалтгаан болж байна. Нийт хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн 34.5 хувь нь 41-50 насны иргэд, ажилласан жилийн хувьд авч үзвэл 46.4 хувь нь 1-3 жил ажилласан байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын тогтооход баримтлах өвчний заалт шинэчлэгдсэнтэй холбоотой хувь өссөн. Нийт актын маягтын зарцуулалтын тоо: хүчингүй актын тоо 14, хүчингүй хурлын шийдвэр 25 байна. ХЧА-ын хувь хугацаа тогтоолгон нийгмийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчийн тоо өмнөх оноос 2.6%-иар өссөн, халамжийн сангаас тэтгэвэр авагчийн тоо 1.3%-иар буурсан үзүүлэлттэй байна. | |
| 4.3.4. | Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | | Төрөлжсөн мэргэшлийн болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо, тайланг хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн болон төрөлжсөн мэргэшлийн, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүд эд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж шинэ мэдээ, мэдээллийг хүргүүлж | ”Авлигын тухай ойлголт, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай” цахим /zoom/ сургалтад Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд, аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч нар 80 хувьтай хамрагдсан. Мөн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар, шинэ нисэх онгоцны буудлын ажилтан мэргэжилтнүүдэд цахим эмнэлгийн хуудас, илгээх зааврын талаар мэдээ мэдээлэл хийсэн. “Аймгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдал, тэргүүлэх өвчлөлийн шалтгаан”, ”Хөдөлмөрийн чадвар алдалтад анхаарах асуудал”, “Цахимаар эмнэлгийн хуудас илгээхэд анхаарах асуудал”, ”Авлигын тухай ойлголт, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн 35 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилласан байна. | эмч мэргэжилтэн хамрагдсан. | |
| Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх | | | | | | | |
| 4.4.1. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | Аймгийн хэмжээнд Татварын байгууллагад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгааг авч нийгмийн даатгалд бүртгэлгүй ч идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын жагсаалтыг гарган хуулийн хэрэгжилтийг хангуулах, сурталчилан таниулах ажлыг хэрэгжүүлэн хамралтыг нэмэгдүүлэн ажиллаж байна.. Аймгийн Татварын газраас авсан судалгаагаар нийт бүртгэлтэй 1165 аж ахуйн нэгж байгуулаас ногдолтой тайлантай 899 байгууллагыг нийгмийн даатгалд хамруууллаа. Татварт "Х" тайлантай 271 аж ахуйн нэгж, байгууллага байна.2024 онд 75 ажил олгогч, 295 албан журмын даатгуулагчийг шинээр нийгмийн даатгалд хамруулсан байна. Дээрх ажлын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн мэдээлэл зөрүүтэй асуудал гараагүй болно. | 100 |
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх | | - Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв | 2024 оны тайланд хугацаад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнаж буй 899 ажил олгогч байгууллагын тайланг Sicos программд шалган хүлээн авч баталгаажуулан ажилласан. Дээрх хугацаанд даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг даатгуулагчийн төрөл код, ажил мэргэжлийн кодыг зөрүүтэй тайлагнасан 98 аж ахуйн нэгж, байгууллагын тайланг залруулан мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлж ажиллав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна. | | |
| | | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байх | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн, зөв гүйцэд шаардаж авсан байна. | | |
| 4.4.2. | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | Албан журмаар болон сайн дураар даатгуулсан даатгуулагч дээр нэг сар давхар бүртгэсэн тохиолдол гараагүй болно. | 100 |
| | | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. | Сайн дураар даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс нь хэтрүүлсэн авлага үүсгэсэн тохиолдол гараагүй болно. | 100 |
| 4.4.3. | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах | | Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг | Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд мэдээллийн шинэ систем нэвтрүүлсэнтэй холбоотой газрын албан хаагчдад албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу программд нэвтрэх эрхийг тохируулах арга хэмжээ авч, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. | байна. | |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | Газарт ашиглагдаж буй програм хангамжуудын шинэчлэл, шинэ системийн хөгжүүлэлтийн талаар ирүүлсэн чиглэл, зөвлөмж, зааврын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Шаардлагатай тохиолдолд үүссэн кэйс, нөхцөл байдлыг НДЕГ-ын Мэдээллийн технологийн төвд тухай бүрт хандан чиглэл, заавар, зөвлөмж авч шийдвэрлэн ажиллалаа. Мэдээлэл технологийн төвөөс зохион байгуулсан цаг үеийн шинжтэй ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь гарган хариу өгч ажиллалаа. | 100 |

ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА .................................................. /С.ОРХОН/